



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2024 оны 04 сарын 18 өдөр

Дугаар 174

Улаанбаатар хот

“Сэлэнгэ АЗЗА” төрийн өмчит хувьцаат компанийн 2023 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин болон Онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээний биелэлтийн тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 9 дэх хэсэг, Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.9 дэх заалт, Хөдөлмөрийн тухай хуулийн 65 дугаар зүйл, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2022 оны 184 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрийн өмчит хуулийн этгээдийн захиралтай онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээ байгуулах, дүгнэх журам”-ын 2.1, 2.3, 3.1, 3.10, 4.3 дахь хэсэг, 2024 оны 108 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.“Сэлэнгэ АЗЗА” төрийн өмчит хувьцаат компанийн 2023 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин болон Гүйцэтгэх захирал М.Батболдтой байгуулсан 2023 оны Онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээний биелэлтийг “Сайн” гэж дүгнэсүгэй.

2.“Сэлэнгэ АЗЗА” төрийн өмчит хувьцаат компанийн Гүйцэтгэх захирал М.Батболдтой Онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээ байгуулах зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллахыг “Авто замын засвар арчлалтын нэгтгэл” төрийн өмчит хувьцаат компанийн Төлөөлөн удирдах зөвлөлд төрийн өмчийн төлөөлөл хэрэгжүүлж буй гишүүдэд үүрэг болгосугай.

3.“Сэлэнгэ АЗЗА” төрийн өмчит хувьцаат компанийн 2023 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшинг ханган биелүүлж, 2023 оны Онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээний биелэлт “Сайн” гэж дүгнэгдсэн тул холбогдох хууль тогтоомжийн дагуу Гүйцэтгэх захирал М.Батболдод хавсралтад заасны дагуу урамшуулал олгосугай.

4.Гүйцэтгэх захирал М.Батболдод хавсралтын дагуу олгох урамшууллыг холбогдох эх үүсвэрээс гаргахыг “Сэлэнгэ АЗЗА” төрийн өмчит хувьцаат компанийн Ерөнхий нягтлан бодогчийн албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (С.Одонтунгалаг) -д зөвшөөрсүгэй.

5.Энэ тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн удирдлага, зохицуулалтын хэлтэс (Ц.Баяр-Эрдэнэ)-т даалгасугай.

ДАРГА

ТӨРИЙН ӨМЧИЙН УДИРДЛАГА,
ЗОХИЦУУЛАЛТЫН ХЭЛТСИЙН
ДАРГА



Б.ЦЭНГЭЛ

Ц.БАЯР-ЭРДЭНЭ

132001321

11-r_huraldaan.docx

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2024 оны 04 дүгээр сарын 18-ны өдрийн
174 дугаар тогтоолын хавсралт



"СЭЛЭНГЭ АЗЗА" ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛД
2023 ОНЫ АЖЛЫН ҮР ДҮНГЭЭР ОЛГОХ УРАМШУУЛАЛ

д/д	Хуулийн этгээдийн нэр	Захирлын нэр	Цэвэр ашиг (мян.төг)	Цэвэр ашгийн дүнгээс хасаж тооцох валютын ханшийн өөрчлөлтөөс олсон ашиг алдагдал (мян.төг)	Урамшуулал тооцох цэвэр ашиг (мян.төг)	Олгох урамшууллын хэмжээ (мян.төг)
1	"Сэлэнгэ АЗЗА" ТӨХК	М.Батболд	46,405.400	0.0	46,405.400	4,640.500 (дөрвөн сая зургаан зуун дөчин мянга таван зуун төгрөг)

.....000.....